МОНГОЛ УЛСЫН
ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН ЯАМ
Улаанбаатар, Чингэлтэй, 4-р хороо, Самбуугийн гудамж,
Засгийн газрын 11-р байр
Утас: 51263333, Факс: 51263333
Цахим шуудан: info@med.gov.mn
Цахим хуудас: www.med.gov.mn

2026.04.07 № 03/898

танай ______________-ны №______________-т

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЯНАЛТ
ХЭРЭГЖҮҮЛЭХ ГАЗРЫН ДАРГА
Б.БАТЦЭЦЭГ ТАНАА

Иргэдээс төрийн байгууллага албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн талаар 2026 оны 1 дүгээр улирлын тайлан, мэдээг хүргүүлж байна.

Хавсралт: 5 хуудастай.

Эдийн засаг, хөгжлийн яам
Удирдлага
Төрийн нарийн бичгийн дарга
Идэш Батхүү
2026-04-07 14:04:04

# ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН ЯАМ ТҮҮНИЙ ХАРЬЯА БАЙГУУЛЛАГУУДАД ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТАНД ХАНДАЖ ИРГЭДЭЭС ИРҮҮЛСЭН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙН 2026 ОНЫ 1 ДҮГЭЭР УЛИРЛЫН ТАЙЛАН

| | |
|---|---|
| 2026 оны 04 дүгээр<br>сарын 06-ны өдөр | Улаанбаатар<br>хот |

“Иргэдээс төрийн байгууллага албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль” Монгол улсын засгийн газрын “Иргэдийн өргөдөл, гомдлыг шийдвэрлэхтэй холбогдсон зарим арга хэмжээний тухай” 2005 оны 67 дугаар тогтоол, Монгол Улсын Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2025 оны А/66 дугаар тушаалаар батлагдсан журмын хүрээнд Эдийн засаг, хөгжлийн яам түүний харьяа байгууллагуудын 2026 оны 1 дүгээр улирлын иргэдээс төрийн байгууллага болон албан тушаалтанд хандаж ирүүлсэн өргөдөл, гомдлын мэдээ тайланг нэгтгэн гаргалаа.

Эдийн засаг хөгжлийн яам болон түүний харьяа байгууллагуудад 2026 оны 1 дүгээр улиралд нийт 148 өргөдөл, гомдол, санал, хүсэлт бичиг хэргээр болон Засгийн газрын Иргэд олон нийттэй харилцах төв /11-11/-өөр дамжин байгууллагын албан бичиг хөтлөлтийн программд бүртгэгдсэн байна.

Өргөдөл гомдлын шийдвэрлэлт:

Хуулийн хугацаанд 134, хугацаа хэтрүүлж өргөдөл, санал хүсэлт гомдлыг шийдвэрлэсэн бөгөөд шийдвэрлэлтийн хувь 90.5 хувийн үзүүлэлттэй байна. Одоогоор 14 өргөдөл, санал хүсэлт, гомдол хуулийн хугацаанд судлагдаж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн 34 дүгээр хуралдаан, 2022 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн 12 дугаар хуралдааны тэмдэглэлд Засгийн газрын гишүүдэд өгсөн үүрэг, даалгаврын дагуу Эдийн засаг, хөгжлийн яаманд ирүүлсэн өргөдөл гомдлыг “Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль” -ийн 16 дугаар зүйлд заасан хугацаанд шийдвэрлэж байгаа бөгөөд цаашид илүү түргэн шуурхай иргэдэд хүндрэл чирэгдэлгүй ажиллаж, үйл ажиллагаагаа улам сайжруулан ажиллахыг зорьж байна.

**ЭДИЙН ЗАСАГ ХӨГЖЛИЙН ЯАМ**

*Хавсралт-1*

# 1.ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН ТӨРӨЛ

/2026 ОНЫ 1 ДҮГЭЭР УЛИРЛЫН БАЙДЛААР/

*2026.01.01-2026.04.01*

| № | Байгууллагын нэр | Өргөдөл гомдлын төрөл | | | | Хүлээн авсан хэлбэр | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Мэдэгдэл | Гомдол | Санал | Хүсэлт | Биеэр | Утсаар | Цахимаар | 11-11 төвөөс шилжүүлсэн | Албан бичгээр | **Нийт** |
| | | **1** | **2** | **3** | **4** | **5** | **6** | **7** | **8** | **9** | |
| 1 | Эдийн засаг, хөгжлийн яам | - | 5 | 2 | 64 | - | - | - | 11 | 60 | **71** |
| 2 | Оюуны өмчийн газар | - | 64 | - | 9 | 10 | - | 8 | 2 | 53 | **73** |
| 3 | Төр хувийн хэвшлийн түншлэлийн төв ТӨААТҮГ | - | - | - | 1 | - | - | - | - | 1 | **1** |
| 4 | Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэн | - | - | - | - | - | - | - | - | - | **-** |
| 5 | Шинжлэх ухааны академи | - | 1 | - | 2 | - | - | - | - | 3 | **3** |
| 6 | Шинжлэх ухааны паркийн захиргаа | - | - | - | - | - | - | - | - | - | **-** |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 7 | Анагаах ухааны хүрээлэн | - | - | - | - | - | | - | - | - | - |
| 8 | МАА-н эрдэм шинжилгээний хүрээлэн | - | - | - | - | - | - | - | - | - | - |
| 9 | Мал эмнэлгийн эрдэм шинжилгээний хүрээлэн | - | - | - | - | - | - | - | - | - | - |
| 10 | Ургамал газар тариалангийн эрдэм шинжилгээний хүрээлэн | - | - | - | - | - | - | - | - | - | - |
| 11 | Үндэсний хөгжлийн хүрээлэн УТҮГ | - | - | - | - | - | - | - | - | - | - |
| 12 | Шинжлэх ухаан технологийн сан | - | - | - | - | - | - | - | - | - | - |
| 13 | Уламжлалт анагаах ухаан технологийн хүрээлэн | - | - | - | - | - | - | - | - | - | - |
| | **БҮГД** | **148** | **70** | **2** | **76** | **10** | **-** | **8** | **13** | **117** | **148** |

*Хавсралт 2*

**ШИЙДВЭРЛЭЛТИЙН БАЙДАЛ**

| Шийдвэрлэж хариу өгсөн | | | | Бусад байгууллагад шилжүүлсэн | | Хугацаа хэтрүүлэн шийдвэрлэсэн /30 хоног/ | Сунгалт хийсэн боловч хугацаа хэтрүүлэн шийдвэрлэсэн /60 хоног/ | Хугацаа болоогүй | Шийдвэрлэх боломжгүй |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Албан бичгээр | Цахимаар | Утсаар | Биечлэн | Харьяаллын дагуу шилжүүлсэн тоо | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн тоо | | | | |
| 117 | 2 | 2 | 10 | 3 | - | - | - | 14 | - |

*Хавсралт 3*

## АГУУЛГЫН ДҮН ШИНЖИЛГЭЭ

| № | Гомдлын агуулга | Тоо | Хувь | Өргөдөл гомдлыг бууруулахад цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний санал |
|---|---|---|---|---|
| 1 | Эдийн засаг хөгжлийн яамны үйл ажиллагаатай холбоотой | 71 | 47.9% | 1. Байгууллагын албан хаагчид ERP систем өргөдөл, гомдол хэсгийг тогтмол шалгаж хэвших<br>2. Өргөдөл гомдол хариуцсан мэргэжилтэн өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн явцад байнга хяналт тавих болон өргөдөл гомдолтой холбоотой мэдээлэл шийдвэрлэлтийн үйл явцыг дэлгэрэнгүй тайлбарлах.<br>3. Иргэдэд оюуны өмчийн зөрчил болон үүнээс үүсэх үр дагавар хариуцлагын талаар зохих мэдлэг олгох ажлыг зохион байгуулах |
| 2 | Шинжлэх ухааны салбарын үйл ажиллагаатай холбоотой | 3 | 2% | |
| 3 | Оюуны өмчийн газрын үйл ажиллагаатай холбоотой | 56 | 37.8% | |
| 4 | Удирдах албан тушаалтны үйл ажиллагаатай холбоотой | - | - | |
| 5 | Бусад | 18 | 12.3% | |